



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын нэр: “Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр дүн, үр ашиг” гүйцэтгэлийн аудит

Аудитын код: ГАГ- ХӨА-2018/01/-ГА

Аймгийн ИТХ-ын захиалга, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаалын дагуу гүйцэтгэсэн гүйцэтгэлийн аудит

Авто зам



Төсөвт өртөг :
638.1 сая
төгрөг
Гүйцэтгэгч:
"Хөвсгөл
АЗЗА" ТӨК

Ахуйн үйлчилгээний барилга



Төсөвт өртөг:
204.3 сая
төгрөг
Гүйцэтгэгч:
"Пазл
солюшн" ХХК

“Сумын төвийн шинэчлэл төсөл”-ийн хэрэгжилтэд тавих хяналт муу, төслийн эцсийн үр дүн харагдахгүй байна.

Цэвэрлэх байгууламж



Төсөвт өртөг:
527.6 сая
төгрөг
Гүйцэтгэгч:
"Сан" ХХК

Мөрөн 2018 он



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ**

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/33

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, 2017 оны А/188 дугаар тушаалын тавдугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын журам”-ын 12.40 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалга, Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу “Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитаар өгсөн албан шаардлагыг хавсралтаар баталгаажуулсугай.

3. Аудитын тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, Засаг дарга болон Засаг даргын Тамгын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Цэцэрлэг сумын Засаг дарга нарт хүргүүлсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2018 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор багтаан Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (Л.Төмөрбаатар), Засаг дарга (Л.Ганболд), Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Ган-Очир), Орон нутгийн өмчийн газрын дарга (Б.Болд), Цэцэрлэг сумын Засаг дарга (Д.Цогт) нарт зөвлөсүгэй.

5. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер /Г.Эрдэнэчимэг/, ахлах аудитор /Ж.Отгончимэг/ нарт даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.ГАНБОЛД

1551133

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дэргэ бөгөөд тэргүүлэх аудиторын 2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 1/23 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



"СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН"-Д ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТААР ӨГӨГДСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

Д/д	Зөрчил хариуцагч байгууллага	Албан шаардлагын дугаар	Өгсөн ажилтан	Зөрчлийн товч утга	Албан шаардлагын дүн /сая төгрөгөөр/
1	Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	01/26	Ахлах аудитор Ж.Отгончимэг аудитор Б.Сандуйжав	Гэрээний хугацаанд төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй	18,2
2	Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	02/27	Ахлах аудитор Ж.Отгончимэг аудитор Б.Сандуйжав	Гэрээний хугацаанд төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй	698,2
Нийт дүн					716,4

___ооОоо___

АГУУЛГА



Тайланг бэлтгэсэн:

**Хөвсгөл аймаг дахь
Төрийн Аудитын газар**

Тэргүүлэх аудитор

О.Ганболд

Аудитын менежер

Г.Эрдэнэчимэг

Ахлах аудитор

Ж.Отгончимэг

Аудитор

Б.Сандуйжав

**2018 оны 06 дугаар
сар**

**Уг тайланг УАГ-ын Веб
сайт-аас үзнэ үү.**

www.audit.mn

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл байвал
70384043 дугаарын
утас, 70383793
дугаарын факсаар
харилцана уу?

ХАЯГ: (Хөвсгөл
аймгийн ЗДТГ-ын А
байр 3 давхарт)

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Ерөнхий зүйл

**БҮЛЭГ-1. Худалдан авах ажиллагааг хууль,
тогтоомжийн дагуу үр дүнтэй, үр нөлөөтэй
зохион байгуулсан байна.**

1.1. Аймгийн Засаг даргын захирамжаар
“Үнэлгээний хороо” байгуулсан байна.

1.2. Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг
хууль, тогтоомжийн дагуу үнэлж, тайлагнасан
байна.

**БҮЛЭГ-2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэмжээний гэрээний хэрэгжилт бодитой бус, үр
нөлөө багатай байна.**

2.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэмжээний гэрээний хэрэгжилт үр нөлөө, үр дүн
муутай байна.

2.2. Хөрөнгө оруулалтын төсөл, арга
хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүн
муутай, зарим арга хэмжээ ашиглалтын
шаардлага хангахгүй байна.

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал
Хавсралт
Тайлангийн хураангуй.....
Тэргүүлэх аудиторын тушаал
Албан шаардлага

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үг	Тайлбар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГА	Гүйцэтгэлийн аудит
ЗГ	Засгийн газар
СС	Сангийн сайд
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТХОТСХТЖ	Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам
ТХОСЖ	Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам
ГЕН	Гэрээний ерөнхий нөхцөл
ГТН	Гэрээний тусгай нөхцөл
УК	Улсын комисс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААН	Аж ахуйн нэгж
ТАХ	Төсөл арга хэмжээ
НББ	Нягтлан бодох бүртгэл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалга, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/125 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2018 оны А/22 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан уу?
- Төслийн хэрэгжилт үр дүн, үр ашигтай байна уу?

Аудитын хамрах хүрээ

Аудитад аймгийн ИТХ, ЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ, ОНӨГ, МХГ, ГХБХБГ, Цэцэрлэг сумын ИТХ, ЗДТГ болон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч ААНБ-ын үйл ажиллагаа болон Цэцэрлэг суманд хэрэгжиж буй “Сумын төвийн шинэчлэл төсөл” хамрагдлаа.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журмыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан байгууллага болон холбогдох ажилтан, албан хаагчидтай уулзаж санал солилцож, тайлбар гаргуулан, амаар зөвлөмж өгч, аймгийн ГХБХБГ, ОНӨГ, ЗДТГ-ын СТСХ, ХОХБТХ-ийн гаргасан судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллалаа.

Шалгуур үзүүлэлтүүд

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамжид заасны дагуу аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Иргэний хууль

- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт тайлагналтын журам”
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2017 оны 363 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан ТХОСЖ /хуучин/
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Ганболд удирдан, аудитын менежер Г.Эрдэнэчимэг аудитын арга зүйгээр хангаж, үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ж.Отгончимэг, аудитор Б.Сандуйжав нар 2018 оны 5 дугаар сарын 10-аас 2018 оны 6 дугаар сарын 30-ны хооронд гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл

МУ-ын ЗГ-ын 2014 оны 309 дүгээр тогтоолоор “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг баталсан байна.

МУ-ын ЗГ-ын 2015 оны 265 дугаар тогтоолоор дээрх тогтоолыг хүчингүй болгож, “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийгдэх ажлын жагсаалтыг шинэчлэн баталсан байна.

МУ-ын ЗГ-ын 2015 оны 265 дугаар тогтоолоор “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийх ажлын технологийн шийдэл болон гүйцэтгэлийн явц, чанар байдал, үр дүн, хөрөнгийн зарцуулалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Барилга хот байгуулалтын сайд болон холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгожээ.

Барилга хот байгуулалтын сайдын 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 32 дугаар тушаалаар “Сумын төвийн шинэчлэл” төслийн /Сумын төвийн айл өрх, албан байгууллагыг цэвэр, бохир ус, дулаанд холбох цэвэрлэх байгууламж байгуулах/ худалдан авах ажиллагааны эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна. Аймгийн Засаг даргын 2014 оны А/118 дугаар захирамжаар байгуулсан үнэлгээний хороо нээлттэй тендер /Түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэй/ 2 удаа зарласан ч гүйцэтгэгч шалгараагүй тул хүчингүй болгосон байна. Иймд: Аймгийн Засаг даргын 2014 оны А/226 дугаар захирамжаар байгуулсан үнэлгээний хороо шууд гэрээ байгуулах аргыг сонгож, улмаар “Сан” ХХК-тай гэрээ байгуулсан байна.

Бүлэг 1: Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу үр дүнтэй, үр нөлөөтэй зохион байгуулсан байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар “Үнэлгээний хороо” байгуулсан байна.

1.1. ЗГ-ын 2014 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн тогтоол болон БХБСайдын 2014 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 32 дугаар тушаалаар “Сумын төвийн шинэчлэл төсөл” (Сумын төвийн айл, өрх, албан байгууллагыг цэвэр, бохир, ус, дулаанд холбох, цэвэрлэх байгууламж байгуулах)-ийг холбогдох хууль, журмын дагуу хурдан шуурхай зохион байгуулж, хэрэгжүүлэх эрхийг аймгийн Засаг даргад үүрэг болгосон байна. Энэхүү шийдвэрээс харахад: ТАХ-ний эрхийг боломжтой хугацаанд шилжүүлсэн байна гэж үзэж байна.

1.2. Цэцэрлэг сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ус, дулаан болон цахилгаан хангамж, ариутгах татуургын гадна шугам сүлжээний зураг, төсөл боловсруулах ажлын даалгавар бэлтгэн БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, аймгийн Засаг дарга нар баталгаажуулсан¹ байна.

1.3. Аймгийн Засаг дарга гүйцэтгэгч “Сан” ХХК-тай 2014.07.23-нд “Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ус, дулаан болон цахилгаан хангамж, ариутгах татуургын гадна шугам сүлжээ, дулааны зуухын шинэчлэл, инженерийн хийцтэй худаг гаргах ажил”, 2014 оны 08 дугаар сарын 13-нд “Ахуйн үйлчилгээний төв, цэвэрлэх байгууламж, хатуу хучилттай авто замын ажил”-ын зураг төсөв боловсруулах даалгаврыг боловсруулан баталсан байна.

1.4. Аймгийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн /Тухайн үед аймгийн Засаг даргаар А.Эрдэнэбаатар ажиллаж байсан/ А/118 дугаар тушаалаар

¹ 2014 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн дугаар 31
ХӨА-2018/01-ГА

9 хүний бүрэлдэхүүнтэй “Үнэлгээний хороо” байгуулсан байна. Тус “Үнэлгээний хороо” нь 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 01-ний өдрийн хооронд ажиллах “Хөтөлбөр” гаргасан байна. Хөтөлбөрийн хүрээнд: 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр сонинд тендерийн урилга /Түлхүүр гардуулах нөхцөлтэй/ нийтэлсэн байна. Энэхүү тендер хүчингүй болж үнэлгээний хороо 2014 оны 05 дугаар сарын 12-нд тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулан дахин бэлтгэсэн байна. 2014 оны 05 дугаар сарын 13-нд **e-procurement.mn** цахим хуудсанд тендерийн урилга /Түлхүүр гардуулах нөхцөлтэй/ байршуулсан байна. Уг тендер мөн хүчингүй болсон байна.

1.5. Аймгийн Засаг даргын 2014 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/243-р захирамжаар үнэлгээний хорооны гишүүнийг нэмж томилсон байна. /Төсөл хэрэгжиж буй сумын төрийн албан хаагчдыг тохиролцсоны дагуу нэмж оруулсан/ Энэхүү үнэлгээний хороо “өөрчлөн бэлтгэсэн тендерийн баримт бичиг”-т үндэслэн сонгон шалгаруулалт явуулсан байна.

1.6. Аймгийн Засаг даргын захирамжаар “Үнэлгээний хороо” байгуулсныг эс тооцвол² үнэлгээний хороог зохих журмын дагуу байгуулсан байна. Байгуулсан “Үнэлгээний хороо” нь холбогдох журмын дагуу ажиллаж тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажилласан байна.

Худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг хууль, тогтоомжийн дагуу үнэлж, тайлагнасан байна.

1.7. Дээр дурдсанчлан энэхүү төсөл арга хэмжээнд³ 2 удаа нээлттэй сонгон шалгаруулалтын аргыг ашиглан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан ч сонгон шалгаруулалт хүчингүй болж “САН” ХХК-тай шууд гэрээ байгуулсан байна. /Шууд гэрээ байгуулах үндэслэл, гэрээний хуулбарыг аймгийн Засаг даргын 2014 оны 09 дугаар сарын 12-ны 1/2300 албан тоотор Сангийн яаманд хүргүүлсэн байна./

1.8. Захиалагч худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын /тухайн үед мөрдөж байсан/ дагуу гаргаж, хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлж ажилласан байна. Тендерийн баримт бичгийг зохих хуулийн дагуу архивын нэгж болгон ОНӨГ-ын архивт хадгалж байгаа боловч баримт бичгийн бүрдэлт хангалтгүй байна.

Бүлэг 2: Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт бодитой бус, үр нөлөө багатай байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт үр нөлөө багатай байна.

² ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйлийн 45.2.2-д “Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь тухайн орон нутагт худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд захиалагч нь байна” гэж заасан.

³ УИХ-ын төсвийн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу хийгдсэн “Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаас

2.1. Үнэлгээний хороо “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийгдэх ажлын 1 дүгээр багцад шалгарсан “Сан” ХХК, “Туурайн тамга” ХХК-тай гэрээ байгуулж ажиллах зөвлөмжийг⁴ аймгийн Засаг даргад хүргүүлсэн байна. Аймгийн Засаг даргын 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 1/1805 албан тоотор “Сан” ХХК, “Туурайн тамга” ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл хүргүүлсэн байна. */Гэрээ болон гэрээний тусгай нөхцөл, бусад холбогдох баримт бичигт хуулийн хугацаанд гарын үсэг зурж 170,0 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг мэдэгдсэн байна/.*

2.2. Үүний дагуу 1 дүгээр багцын ажлыг 2014 оны 08 дугаар сарын 15 –ны өдрөөс 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдөр дуусгахаар гэрээ байгуулсан байна. Гэрээнд ГЕН болон ГТН-ийг тусгаж байгуулсан байна. 2 дугаар багцын ажлыг 2014 оны 09 дүгээр сарын 01-нээс эхлэн 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдөр дуусгахаар гэрээ байгуулсан ба ГЕН болон ГТН байхгүй байна. Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа давхацсанаас багц 2-ын ажлын гэрээний хугацааг 2015 оны 07-р сарын 28-нд эхэлж, 2015 оны 09-р сарын 01-нд ашиглалтад оруулахаар гэрээний сунгалт хийсэн байна⁵. Энэхүү сунгалт хийсэн гэрээнд ГЕН болон ГТН-ийг тусгасан байна.

2.3. Захиалагч 2015 оны 09 дүгээр сарын 02-ны өдөр гүйцэтгэгч “Сан” ХХК-тай байгуулсан хоёрдугаар багц ХӨ-2014/84-А-02, ХӨ-2014/84-А-07 дугаартай гэрээнд */Гэрээ сунгах шалтгаан тодорхой бус байна./* сунгалт⁶ хийж Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төвд хатуу хучилттай авто зам, дулааны эх үүсвэр барих, ахуйн үйлчилгээ, халуун ус, цэвэрлэх байгууламж, гүний худаг, усан сангийн барилга, гадна, цахилгаан, дулаан, цэвэр, бохир, усны шугамын угсралтын ажлуудын гүйцэтгээгүй хэсэг болох 1 тэрбум 600 сая төгрөгийн дутуу өртөгтэй ажлыг үе шатны хуваарьт зааснаар 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдөр, 2016 оны 6 дугаар сарын 01-ний өдөр хүртэл 2 үе шаттайгаар хэрэгжүүлж дуусгахаар тохиролцсон байна.

2.4. Аймгийн Засаг даргын 2016 оны А/289 дүгээр захирамжаар байгуулсан “Төслийн баг” төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй танилцан “Төсвийн орлого тасарсантай холбогдуулан санхүүжилтийг хуваарийн дагуу олгоогүйгээс “Сан” ХХК-тай байгуулсан гэрээг сунгах нь зүйтэй” гэж шийдвэрлэсэн байна. Шийдвэрийн дагуу 2 дугаар багцын гэрээг 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдөр эхэлж, 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр ашиглалтад оруулахаар дахин сунгасан байна. Энэхүү гэрээнд доорх ажлуудыг дуусгахаар заасан байна Үүнд:

- Авто замын угсралтын ажил 407,9 сая төгрөг
- Гадна цахилгааны ажил 20,3 сая төгрөг
- Халуун усны барилгын ажил 86,5 сая төгрөг
- Ахуйн үйлчилгээний барилга 136,9 сая төгрөг
- Цэвэрлэх байгууламжийн ажил 153,4 сая төгрөг
- Усан сангийн барилгын ажил 120,0 сая төгрөг нийт 925,1 сая төгрөгийн ажлыг

2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр дуусгахаар гэрээ байгуулсан хэдий ч дээрх ажлыг улсын комисс бүрэн гүйцэд хүлээж авч ашиглалтад оруулаагүй байна. */Ийнхүү тохиролцсон хэдий ч өнөөг хүртэл дуусгаагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй, сунгасан эсэх талаар нотлох баримт байхгүй байна./*

⁴ Аймгийн ЗДТГ-ын ХААА-ны /хуучин нэршлээр/ 2014.07.03-ны 183 албан тоот

⁵ “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын дүнгээс авсан болно.

⁶ Сунгалт хийсэн гэрээний дугаар /ХӨ-2015/7.15/

2.5. Гэрээний хугацаанд бүрэн ашиглалтад хүлээж аваагүй шалтгааныг тодруулахад ямар нэгэн баримтгүй байна. Аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн А/516 дугаар захирамжаар байгуулагдсан “Ажлын хэсэг” гүйцэтгэгч, ашиглагч, зохиогчийг байлцуулан 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр төслийн хүрээнд хийгдсэн ажлуудад өмнө өгсөн үүрэг даалгаврын биелэлт шалгах, ашиглалтад хүлээн авах нэгдсэн дүгнэлт гаргахаар хэлэлцсэн байна. Үүний үр дүнд захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч нар дутуу ажлыг гүйцээж хийх гурван талт гэрээ байгуулсан байна. Энэхүү гэрээгээр ажил дуусах хугацааг 2018 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөр тохиролцсон байна.

2.6. Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийгдэж буй ажлуудын гэрээнүүдэд сунгалт хийсэн байдлаас харахад: Улсын комисс хүлээж авсан зарим ажлуудын гэрээг дахин сунгасан байна.

Улсын комисс хүлээж авсан ажлуудыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1: Төсөл, арга хэмжээг улсын комисс хүлээж авсан байдал

№	Төсөл, арга хэмжээний нэр	Улсын комисс хүлээж авсан актын огноо	Тайлбар
1	Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил	2016.10.23	-
2	Гүний худаг гаргах ажил	2016.10.23	Гурван талт гэрээгээр 2018.07.01 хүртэл сунгасан.
3	Гадна дулааны шугамын угсралт	2016.10.23	Гурван талт гэрээгээр 2018.07.01 хүртэл сунгасан.
4	Уурын зуухны тоног төхөөрөмжийн шинэчлэл	2016.10.23	Гурван талт гэрээгээр 2018.07.01 хүртэл сунгасан.
5	Гадна бохир усны шугамын ажил	2016.10.23	УК хүлээж авсан гэх боловч УКА байхгүй байна.
6	Усан сангийн барилгын ажил	2016.10.23	
7	Цахилгаан хангамжийн ажил	2016.10.15	Ажил гүйцэтгэх гэрээг 2016.11.01 хүртэл сунгасан.
8	Халуун усны барилгын ажил	2016.10.23	Ажил гүйцэтгэх гэрээг 2016.11.01 хүртэл сунгасан. Мөн гурван талт гэрээгээр 2018.07.01 хүртэл сунгасан.

2.7. Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3⁷, 14.6⁸ дахь хэсэгт Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах, хэвийн ашиглалтын хугацааг заасан бөгөөд мөн хуулийн 14.4⁹, 14.7¹⁰ дахь хэсэгт энэ хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, ашиглагч, гүйцэтгэгч, зохиогч үзлэг хийж арилгаж, улмаар буруутай этгээд хохирлыг барагдуулахаар заасан байна. Дээрх хүснэгтээс харахад: Ашиглалтад хүлээн авсан төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг сунгасан нь энэхүү хуулийн заалттай нийцэхгүй байна. Иймд: Ашиглалтад хүлээж аваагүй ТАХ-г яаралтай ашиглалтад оруулах “**Албан шаардлага**”-ыг аудитын хугацаанд Захиалагчид хүргүүлэн ажиллав.

⁷ 14.3-д Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна.

⁸ 14.6-д Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

⁹ 14.4 Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ.

¹⁰ 14.9 Энэ хуулийн 14.6-д заасан хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулна.

“Сан” ХХК нь “Туурайн тамга” ХХК-тай түншлэлийн гэрээтэй тендерт оролцсон ч нилээдгүй олон ХХК-тай гэрээ байгуулан ажлуудыг гүйцэтгүүлсэн нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 41 дүгээр зүйлийн 41.2-дахь (Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно) гэсэн хэсгийг зөрчсөн байна.

2.8. Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг авч үзвэл: Гүйцэтгэгч “Сан” ХХК, “Туурайн тамга” ХХК нь барилга угсралт, инженерийн шугам сүлжээний ажлыг зураг, төсвийн дагуу, хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэн гэх боломжгүй байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд гарсан зөрчлийг ангилан харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Зураг, төсвийн дагуу гүйцэтгээгүй төсөл, арга хэмжээ.

Шугам хоолойн угсралтын ажил: Уг ажлыг гүйцэтгэхдээ анхны зураг төслөөс өөрчилсөн /трасс/ бөгөөд гүйцэтгэлийн зураг төсөв хийж баталгаажуулаагүй, батлагдсан зураг төсөлд тусгагдаагүй дулаалгын материал болох “Корунд”-аар шугам хоолойн дулаалгыг хийж гүйцэтгэсэн нь Монгол Улсын Барилгын тухай хуулийн 40 дугаар зүйлийн 40.1.17 дахь заалт (барилгын ажлын явцад зураг, төсөл өөрчлөгдсөн бол гүйцэтгэлийн зураг төсөл боловсруулж баталгаажуулах)-ыг зөрчсөн байна¹¹. Ил үзлэгээр дараах зөрчил илэрсэн. Үүнд:

- Уурын зуухны барилгын гадна талыг өнгөлсөн гэж харагдахааргүй зөвхөн өнгөц шавар хийсэн, уурын зуухны яндан хазайсан.
- Цэвэр усны шугам хоолойг дулаалаагүй.
- “Корунд”-аар дулаалсан хэсэгт зэвэрсэн, /зэврэлтээс хамгаалсан түрхлэг түрхсэн гэх боломжгүй/ цоохортсон, багсны оромтой байна. г. м-ийн зөрчил нэлээдгүй байна.

Ашиглагч байгууллагуудаас өвлийн улиралд маш хүйтэн, дулааны алдагдал ихтэй гэж тайлбар мэдээлэл ирүүлсэн.

Зураг 1: Шугам, хоолойн угсралтын ажил



Шугам хоолойн дулаалгын байдал



Уурын зуухны барилгын гадна талын өнгөлгөө

Ахуйн үйлчилгээний барилга: Батлагдсан зураг, төсөвтэй тулган шалгахад дараах ажлууд зөрүүтэй хийгдсэн байна. Үүнд: Гадна шат довжоог зургийн дагуу хийгээгүй, агааржуулалтын системийг өрлөгөөр хийхээр зурагт тусгасныг хуванцар хоолойгоор хийсэн байна.

¹¹ Аймгийн МХГ-ын Эрчим хүчний хяналтын улсын байцаагч Ч.Цэрэнсүрэн нэгдсэн халаалтын системийн шугам сүлжээний зураг төсөл, угсралтын байдалд үзлэг шалгалт хийж гаргасан дүгнэлт.

Зураг 2: Ахуйн үйлчилгээний барилгын ажил



Агааржуулалтын систем болон гадна довжооны гүйцэтгэл

Авто замын ажил: Сумын төвд баригдсан авто замын дагуу шуудуу татахаар зурагт тусгасан ч энэхүү ажлын оронд уулын үерийг зайлуулах шуудуу татсан байна. Өөрчлөлт хийсэн зохиогчийн зөвшөөрөл байхгүй ба УК-ын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд “Төслийн баг хэлэлцэж байгаад шилжүүлэн хийлгэсэн” гэж бичсэнээс өөр шийдвэргүй байна. Энэ нь: Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-дэх “Зураг төслийн дагуу баригдсан байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Зураг 3: Авто замын ажлын гүйцэтгэл




Авто зам дагуух шуудууг өөрчлөн ууланд шуудуу татсан байдал

Зөрчилтэй төсөл, арга хэмжээ.

Ахуйн үйлчилгээний барилга: Ханын битүүмжлэл муу хийгдсэнээс шал хананы завсраар шороо, цас орж байна.

Зураг 4: Ахуйн үйлчилгээний барилгын гүйцэтгэл



Ханын битүүмжлэл муугаас шороо орсон байдал

Цэвэрлэх байгууламж: Ханын битүүмжлэл муу хийгдсэнээс шал, хананы завсраар шороо, цас орж байна. Үүний улмаас дулаан алдагдал ихтэй, халаах хэрэгсэл

барилгыг халааж чадахгүй байна. Лагийн болон цэвэрлэгдсэн усны шугам хоолой дулаалга хангалтгүйгээс өвлийн улиралд хөлдсөн байна. Лагийн талбай болон ус зайлуулах хоолой өвлийн улиралд цасанд дарагдаж ашиглалтын байдалд саад учруулж байна.

Зураг 5: Цэвэрлэх байгууламжийн ажлын гүйцэтгэл



Ханын битүүмжлэл, цэвэрлэсэн ус зайлуулах хоолой хөлдсөний улмаас хагарсан байдал

Халуун усны барилга: Чийг ихтэй байгаагаас дотор засал ховхорч мөөгөнцөр үүсэх шинж тэмдэг илэрсэн байна. Агааржуулалт муу ажиллаж, цанталт үүсэн агааржуулалтаас ус гоожсон байна. Халуун усны гадна цэвэр усны шугам дулаалгагүй учраас хөлдөлт үүссэн байна.

Зураг 6: Халуун усны барилгын ажлын гүйцэтгэл



Дотор засал ховхорсон байдал

Хөлдсөн хоолой

Усан сангийн барилга: Ус нөөцлөх савыг хавтангууд залгаж хийсэн бөгөөд савны нийт эзлэхүүний хэмжээгээр ус нөөцлөх үед хавтангуудын залгаасаар ус алддаг болсон байна.

Зураг 7: Усан сангийн барилгын ажлын гүйцэтгэл



Ус нөөцлөх сав /Залгаасаар ус алдалттай/

2.9. 2016 оны 10 дугаар сарын 23-ний өдөр 16 хүний бүрэлдэхүүнтэй “**Улсын комисс**” хүлээж авсан боловч холбогдох баримт бичгүүдийг архив болон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байна. /Ашиглагч байгууллага ашиглаж байна/

2.10. “**Улсын комисс**” нэлээдгүй олон ажлыг хийлгэх үүрэг даалгавар хүргүүлсэн боловч үзлэг шалгалтаар тухайн ажлууд нь хийгдсэн гэх нотлох баримтгүй, Улсын комисс өгсөн үүрэг даалгавраа заасан хугацаандаа шалгасан гэх нотлох баримт байхгүй байна.

Иймд: Дээрх үзлэг шалгалтаар илэрсэн зөрчилд үндэслэн ТАХ-ний гүйцэтгэлийг Улсын комисс зохих журмын дагуу хүлээж авсан гэж үзэх боломжгүй байна. **Тодруулбал:** Акт үйлдэн бүгд гарын үсэг зурсан боловч хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нотлох баримтад тулгуурлан шалгаагүй, холбогдох баримт бичгийг архивын нэгж болгон бүрдүүлж, аймгийн архив болон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байна. Энэ нь: Барилгын тухай хуулийн 46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг 46.3. дахь “Хөрөнгө оруулагч, захиалагч ашиглалтад оруулсан барилга байгууламжийн газрын зөвшөөрөл, тэг тэнхлэг таталтын акт, зураг төсөл, ил, далд ажлын акт, гадна шугам сүлжээний гүйцэтгэлийн зураг, барилгын ажлын явцад захиалагч, зохиогч, улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагын чанар, аюулгүй байдлын талаар гаргасан дүгнэлт, **ашиглалтад оруулсан баримт бичгийг тухайн барилга байгууламжийг ашиглалтад оруулснаас хойш 30 өдөрт багтаан холбогдох архивт шилжүүлнэ**” хэсгийг зөрчсөн үйлдэл болсон байна. Мөн улсын комисс нь Монгол Улсын ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоолоор баталсан дүрмийг бүрэн гүйцэд хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Дүрмийн 4.6. дахь заалт (Зураг төсөл зохиогч, захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч, гүйцэтгэгч талууд хамтран тухайн барилга байгууламжид техникийн болон чанарын үзлэг, шалгалт хийж дотоодын хяналтын дүгнэлт гаргана. Энэхүү дүгнэлтийг энэ дүрмийн 4.5-д заасан материалд хавсаргасан байна.)

- Дүрмийн 4.12.7. дахь хэсэг (Комиссын гишүүд мэргэжлийнхээ чиглэлээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулсны дараа энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтад заасан актад гарын үсэг зурж баталгаажуулна. Зөрчил дутагдлыг 14 хоногт бүрэн арилгасан байна. Комиссын актыг баталгаажуулаагүй тохиолдолд комисс дахин ажиллах бөгөөд үүнтэй холбогдож гарах зардлыг захиалагч хариуцна) гэсэн хэсгүүдийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

“Сумын төвийн шинэчлэл” төслийн 5 тэрбум төгрөгийн ТАХ нь иргэд ААН, байгууллагад үр өгөөжөө хангалттай, үр дүнтэй, үр ашигтай өгч чадахгүй байна гэж гүйцэтгэлийн аудитаар үзэж байна. **Тодруулбал:**

5 тэрбум төгрөгийн төслөөр хэрэгжсэн арга хэмжээнээс 4 ТАХ-г улсын комисс бүрэн хүлээж аваагүй, төслийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

2.11. ТАХ-ний гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулсан гэх нотлох баримт байхгүй байна. Аймгийн ОНӨГ “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд хийгдсэн ажлаас **зөвхөн** дулааны зуух, дулааны шугам сүлжээний үйл ажиллагаа, өнөөгийн байдалд үнэлгээ өгөх, зөвлөмж боловсруулах зөвлөх үйлчилгээг 15,0 сая төгрөгөөр хийлгэсэн байна.

2.12. Мэргэжлийн дүгнэлтийг Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнтэй №2016/7.20-зөвлөх-02 дугаартай гэрээ байгуулан хийлгэсэн байна. Уг байгууллага мэргэжлийн баг хамт олон ажиллуулж шинжилгээ, судалгааны үндсэн

дээр дүгнэлт, зөвлөмж гаргаж хүргүүлсэн байна. Гэсэн хэдий ч уг зөвлөмжийн мөрөөр ямар арга хэмжээ авч ажилласан талаар нотлох баримт байхгүй байна.

2.13. Зөвлөх үйлчилгээний дүгнэлтэд: “Корунд” тусгаарлагчаас шилэн хөвөн дулаан тусгаарлагч сайн тусгаарлаж байгааг тодорхойлов” гээд, дулааны алдагдлыг багасгах зорилгоор “Корунд” дулаалгыг сайжруулах эсвэл давхарлаж шилэн хөвөн буюу хөөсөнцөр дулаалга хийх зэрэг 7 зүйлийн зөвлөмж өгсөн байна. Эдгээр зөвлөмжөөс ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах гэсэн зөвлөмжөөс бусад нь хэрэгжээгүй байна.

Зөвлөх үйлчилгээ 15,0 сая төгрөгөөр хийлгээд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үр дүнгүй зарцуулсан байна гэж гүйцэтгэлийн аудитаар үзэж байна.

2.14. ТАХ-ний урьдчилгаа болон ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийн баримтыг тухайн үед мөрдөгдөж байсан СС-ийн 290 дүгээр тушаалаар баталсан журмын дагуу аймгийн ЗДТГ-ын ХБХ /хуучин нэрээр/ -ийн мэргэжилтэн эхний гүйцэтгэлийг хянан баталгаажуулж 2071,9 сая төгрөгийг олгосон байна. Үлдэгдэл санхүүжилтийг БХБЯам өөрөө хариуцан /захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн/ олгосон байна.¹²

2.15. ТАХ-ний хэрэгжилтийг зохих журмын дагуу хугацаанд нь тайлагнаж холбогдох Яаманд хүргүүлсэн гэх нотлох баримт байхгүй байна. Иймд: СС-ын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмын 6.4-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг дараа оны 04 дүгээр сарын 10-ны дотоод энэ журмын наймдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж СС-д хүргүүлнэ” гэсэн хэсгийг зөрчсөн байна. /хуучин журмын 5.5/

2.16. БХБСайдын 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын 9-д Захиалагчийн хяналтын гэрээг хууль, дүрмийн дагуу байгуулж, хяналтын инженерүүдийг томилон үе шатны ажил дуусах бүрд шалгаж баталгаажуулан, баримт материал бүрдүүлж, санхүүжилтийн болон ажлын тоо хэмжээний гүйцэтгэлийн тайлан, мэдээг сар бүрийн 20-ны өдрийн дотор Барилга, хот байгуулалтын яамны Орон сууц, нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт ирүүлж байх гэж даалгасан боловч энэхүү даалгаврыг хэрэгжүүлж ажилласан гэх нотлох баримт байхгүй байна.

Дээрх зөрчлөөс харахад: ТАХ-ний **хэрэгжилтийг** зохих журмын дагуу хугацаанд нь тайлагнаж холбогдох Яаманд хүргүүлсэн гэх боломжгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүн муутай, зарим ТАХ ашиглалтын шаардлага хангахгүй байна.

2.17. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн зүгээс тавих үе шатны хяналтыг хугацаанд нь бүрэн хэрэгжүүлсэн гэж үзэх боломжгүй байна. Захиалагчийн хяналтын зардлыг “Захиалагчийн хяналтын зардал” дансаар дамжуулахгүй шууд зарцуулсан байна. Мөн уг зардлын зарим нэгэн хэсгийг зориулалт бусаар зарцуулсан байна.¹³

¹² БХБЯам нь гэрээг сунгаж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан гэж аймгийн ГХБХБГ-аас тайлбарласан бөгөөд аймгийн Төрийн сангаар үлдэгдэл санхүүжилт дамжаагүй байна. БХБЯ-аас үлдэгдэл санхүүжилтийг олгосон тул орон нутагт баримт материал байхгүй байна.

¹³ УИХ-ын төсвийн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоол, МУ-ын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөөний дагуу хийгдсэн “Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитаас

2.18. Төслийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хэсэг болон улсын комисс удаа дараа ажиллан үүрэг, даалгавар өгсөн ч заасан хугацаандаа үүрэг, даалгаврын биелэлтээ хангуулдаггүй, үүний улмаас гэрээг дахин дахин сунгах нөхцөл байдал үүсэж төслийн үр өгөөж төдий хэмжээгээр хойшлогдож байна. Гэтэл: Гүйцэтгэгчтэй ямар нэгэн хариуцлагын арга, хэмжээ тооцож ажиллаагүй байна. **Дурдвал:**

- Халуун усны барилгыг 2015 оны 09 дүгээр сарын 01-нд хэрэгжиж дуусахаар гэрээнд заасан ч улсын комисс 2016 оны 10 дугаар сарын 23-нд хүлээн авсан бөгөөд гэрээний хугацаа хэтрүүлсний алдангийг огт тооцоогүй, улмаар гэрээг 2016 оны 11 дүгээр сарын 01 хүртэл сунгасан.
- УК-ын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний хурлын тэмдэглэлд: Ахуйн үйлчилгээний барилгын гүйцэтгэлд гарсан зөрчлийг арилгуулан 2017 оны 10 дугаар сарын 20-нд хүлээн авахаар гүйцэтгэгчид үүрэг даалгавар өгсөн ч хэрэгжилтийг хангуулж ажиллаагүй байна.

2.19. Орон нутгийн /Цэцэрлэг сум/ зүгээс хэрэгжүүлсэн хяналтыг авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд: Цэцэрлэг сумын Засаг дарга 2014 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/100 дугаар тушаалаар “Сумын төвийн шинэчлэл төсөл”-ийн ажлын явцад хяналт тавих “Ажлын хэсэг” байгуулж, ажлын явцын тайлан мэдээг 7 хоног бүр гарган тайлагнаж ажиллахыг үүрэг болгосон байна. Энэхүү ажлын хэсэг хяналт тавьж ажилласан гэж тайлбарлаж байгаа ч ажлын хэсгийг хяналт тавьж ажилласан гэх нотлох баримт байхгүй байна. Уг комисс-т орж ажиллаж байсан зарим нэгэн албан тушаалтан сонгуулийн үр дүнд ажлаас чөлөөлөгдсөн байна.

Ажлын хэсгийг дахин өөрчлөн байгуулж ажиллах болон тухай үед хариуцлагагүй ажилласан албан тушаалтанд хариуцлагын арга хэмжээ авч ажиллах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.20. Ахуйн үйлчилгээний барилгыг ашиглалтад хүлээн аваагүй бөгөөд халаалтаар хангаж байна. Энэ нь: Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2¹⁴-дахь хэсгийг зөрчсөн бөгөөд “Тэсийн илч” ОНӨХХК жилд халаалтын төлбөр болох 4.5 сая төгрөгийн алдагдалд орж байна.

2.21. Ашиглагчийн зүгээс төсөл, арга хэмжээний ашиглалттай холбоотой дараах хүндрэл, бэрхшээл байгаа талаар санал, хүсэлт гаргасан. Үүнд:

- Усан сангийн цэвэр ус нөөцлөх сав залгаасаараа ус алдаж байгаагаас усыг боломжит хэмжээнд нөөцлөх боломжгүй, ойр ойрхон ус татах шаардлага үүсэж ажиллах хүчний болон ашиглалтын /цахилгааны/ үргүй зардал гарч байна.
- Цэвэрлэх байгууламжийн халаалтыг цахилгаанаар халаахаар шийдвэрлэсэн нь цахилгааны зардал их гарч байгаа, барилга нь дулаан алдагдал ихтэй зэргээс барилгыг бүрэн халааж чадахгүй байна. Хүйтний улиралд ердийн зуух тавьж халаасан.
- Халуун усны барилгын ус халаах систем нь бүрэн хүчин чадлаар ажиллах үед усаа халааж чаддаггүй, цахилгааны зарцуулалт ихтэй зэргээс түрээслэн ажиллуулж байгаа иргэд нь халаалтын төлбөр өгөх боломжгүй байна. Үүний

¹⁴ Барилга байгууламжийг барилгын ажлын явцад шаардагдах цахилгаан, дулаан, халуун, хүйтэн усаар түр хангах бөгөөд байнгын ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг цахилгаан, харилцаа холбоо, дулаан, халуун, хүйтэн усаар хангахыг хориглоно.

улмаас түрээслүүлэгч жилд 1.1 сая төгрөгийн халаалтын төлбөрийн орлого олох боломжоо алдаж байна.

- Гүний худаг: Ундны усанд хэрэглэж болохгүй гэсэн “Дүгнэлт” гарсан ч захиалагч, гүйцэтгэгчийн аль нь ч ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Дээрх байдлаас харахад: Зарим төсөл, арга хэмжээ ашиглалтын шаардлага хангахгүй алдаа, дутагдал ихтэй байна.

2.22. Дууссан ТАХ-г Нягтлан бодох бүртгэлд бүртгэж ажиллаагүй байна. **Тухайлбал:** Цэвэрлэх байгууламжийн ажил, Ахуйн үйлчилгээний барилгын ажлаас бусад барилга, инженерийн хийцтэй шугам сүлжээг УК 2016 онд хүлээн авч акт үйлдсэн хэдий ч өнөөг хүртэл орон нутгийн өмчид бүртгэн, Нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна. Энэ нь: МУ-ын СС-ын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 5.1-дэх “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил нь төрийн, **эсхүл орон нутгийн өмчид заавал бүртгэгдэх** бөгөөд барилга байгууламж, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр төсөвт байгууллагын тайлан балансад бүртгэнэ, Их засварын зардлыг захиалагч байгууллага нь хөрөнгийн дүн, засварын төрлөөр тодруулга тайланд тусгана” гэсэн хэсгийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.23. Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийгдсэн ажлыг Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна. Мөн төсөл хэрэгжсэн Цэцэрлэг суманд энэхүү мэдээллийг иргэд, олон нийтэд мэдээлээгүй байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 5964,4 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлж, 716,4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах “**Албан шаардлага**”, зарим нэгэн алдаа зөрчлийг арилгах хугацаатай зөвлөмжийг холбогдох газруудад хүргүүлж ажиллав.

Зарим нэгэн алдаа /Шугам хоолойн ажил/ зөрчилд МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлт гаргуулан зөрчлийг арилгуулах “**Албан шаардлага**” хүргүүлж ажиллав.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу үр дүнтэй, үр нөлөөтэй зохион байгуулсан байна.
2. Шугам хоолойн угсралтын ажлыг гүйцэтгэхдээ анхны зураг төслөөс өөрчилсөн /трасс/ бөгөөд гүйцэтгэлийн зураг төсөв хийж баталгаажуулаагүй, гүйцэтгэгч нь батлагдсан зураг төсөлд тусгагдаагүй дулаалгын материал болох “Корунд”-аар шугам хоолойн дулаалгыг хийж гүйцэтгэсэн байна.
3. ТАХ-ний хэрэгжилтийг зохих журмын дагуу хугацаанд нь тайлагнаж холбогдох Яам, газарт хүргүүлээгүй байна.
4. Зөвлөх үйлчилгээ хийлгээд, түүнээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үр дүнгүй зарцуулсан, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүн муутай, зарим ТАХ ашиглалтын шаардлага хангахгүй байна.
5. Улсын комисс ажиллаж ТАХ-ыг хүлээн авсан гэх боловч ажлын дуусгалт хангалтгүй, хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг нотлох баримтад тулгуурлан шалгаагүй, холбогдох баримт бичгийг архивын нэгж болгон бүрдүүлж, аймгийн архив болон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байгаагаас ТАХ-ний гүйцэтгэлийг Улсын комисс зохих журмын дагуу хүлээж авсан гэж үзэх боломжгүй байна.
6. Цэвэрлэх байгууламжийн ажил, Ахуйн үйлчилгээний барилгын ажлаас бусад барилга, инженерийн хийцтэй шугам сүлжээг улсын комисс 2016 онд хүлээн авч акт үйлдсэн хэдий ч өнөөг хүртэл орон нутгийн өмч, Нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.
7. Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийгдсэн ажлыг Шилэн дансны цахим хуудас, төсөл хэрэгжсэн Цэцэрлэг суманд энэхүү мэдээллийг иргэд, олон нийтэд мэдээлээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Л.Ганболд-д

1. Ашиглалтад орсон барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах ажлыг зохион байгуулах
2. Барилга байгууламжийн нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээллийн сан буй болгох, хяналт тавих
3. Улсын комисст ажилласан албан хаагчдад ажлын хариуцлага тооцож, дутуу ажлуудыг гүйцэтгүүлэх.

ОНӨГ-ын дарга Б.Болд-д

1. Тендерийн баримт бичгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсруулан бүрэн гүйцэд үнэн зөв бэлтгэж архивт хүлээлгэн өгөх
2. Улсын комисс хүлээн авч ашиглалтад оруулсан барилга байгууламж, инженерийн шугам сүлжээг орон нутгийн өмчид бүртгэх асуудлыг зохион байгуулж ажиллах

Аймгийн ГХБХБГ-ын дарга Н.Бямбадорж-д

1. Барилга байгууламжийн баримт бичгийг холбогдох хууль, тогтоомж, норм, нормативын баримт бичгийн шаардлагын дагуу бүрдүүлж, хяналт тавьж ажиллах
2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.4.1-д заасны дагуу барилга байгууламж болон үйл ажиллагааныхаа талаарх иж бүрэн мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт нийтэд ил тод байршуулах
3. Барилгын үе шатны ажилд хяналтыг хэрэгжүүлэхдээ Барилгын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.20-д заасан гэрээг байгуулж, үр дүнг тооцож ажиллах
4. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах
5. Барилга байгууламжийн баримт бичгийг үнэн зөв бүрдүүлэх, баяжуулалт хийх.
6. Шугам хоолойн дулаалгын ажлыг дахин хийлгэх ажлыг зохион байгуулж ажиллах.
7. Зөрчилтэй ТАХ-нүүдийн зөрчлийг бүрэн гүйцэд арилгах, тухайн ажилд үе шатны хяналт хийж ажилласан инженер техникийн ажилтанд ажлын хариуцлага тооцож ажиллах.

Аймгийн ЗДТГ-ын ХЗХ-ийн Архивын тасгийн эрхлэгч Ж. Жаргалсайхан-д

1. “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд баригдаж, ашиглалтад орсон барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ажлын баримт бичгийг холбогдох хуулийн дагуу */шалгуур үзүүлэлтийн/* хүлээн авч архивлах ажлыг зохион байгуулж ажиллах

Цэцэрлэг сумын Засаг дарга Д.Цогт-д

1. Сумын “Дотоод хяналтын нэгж”-ийг зохион байгуулж, хагас бүтэн жилээр үр дүнг тооцож ажиллах, тухайн үед “Ажлын хэсэг”-т ажиллаж байсан албан хаагчдад ажлын хариуцлага тооцож ажиллах.
2. Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хийгдэж, ашиглалтад орсон төсөл, арга хэмжээний талаар иргэд олон нийтэд ил тод мэдээлж ажиллах.

Цэцэрлэг сумын ААНБ-ын дарга, эрхлэгч нарт

1. Дулааны шугам сүлжээний байгууламжийн оролт, гаралтад дулаан хэмжигч хэрэгсэл байршуулах.

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын тайлбар
Аймгийн ГХБХБГ-аас ирүүлсэн санал	
<div data-bbox="491 394 896 696" style="text-align: center;"><p>ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР 67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 7 дугаар баг, Утас, факс: 70382829 E-mail: khovsgol@gazag.gov.mn</p><p><i>2018.06.27</i> № <i>4/283</i> талай _____ -ны № _____ -т</p><p>ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ</p></div> <p data-bbox="389 719 941 815">Цэцэрлэг суманд хэрэгжсэн "Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр ашиг" гүйцэтгэлийн ГАГ-ХӨА-2018/01/-ГА кодтой аудитын тайлангийн тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.</p> <p data-bbox="453 837 676 864">Хавсралт хуудастай.</p> <div data-bbox="421 898 909 1088" style="text-align: center;"><p>БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ЭНХЖАРГАЛ</p></div> <p data-bbox="699 1317 893 1344">D:\Documents \toot\</p>	<p data-bbox="1134 490 1525 703">Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг тухай бүр танилцуулан, санал солилцож, нотлох баримтад тулгуурлан ажилласан бөгөөд тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.</p>

Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газрын Цэцэрлэг сумын “Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр ашиг” гүйцэтгэлийн ГАГ-ХӨА-2018/01/-ГА кодтой аудитын тайлангийн төслийн тайлбар

2018.08.27

Мөрөн сум

2.3. Тус ажлыг 2014 онд “Сан”ХХКомпани ерөнхий гүйцэтгэгч, “Туурайн тамга” ХХКомпани туслан гүйцэтгэгчээр түншлэлийн гэрээгээр орж түлхүүр гардуулан нөхцлөөр гэрээ байгуулан ажиллаж эхэлсэн. Тус ажлын санхүүжилт удаашралтай байгаагаас шалтгаалан гэрээний хугацаа хоцорч гүйцэтгэгдэж байсан. Гэрээний хэрэгжилтийг гэрээний субъектүүдтэй тооцох болохоос бусад компаниудтай тооцохгүй гэдэг зөрчмөг баримталж ажилласан. 2016 оны 10 дугаар сарын 23-н улсын комисс ажиллахад гүйцэтгэгч компани ажлын гүйцэтгэл 95%-ийн гүйцэтгэлтэй байсан боловч 3.1 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байсан. Тус төслийг гүйцэтгэж эхлэхдээ 2014 оны 9 дүгээр сарын 15-нд байгуулсан ерөнхий гэрээний тусгай нөхцлийг үндэслэн дараах гэрээнийг байгуулж байсан. Бусад гэрээнүүд нь тус гэрээний хавсралтаар хийгдэж байсан болно. Гэрээг 2017 оны 10 дугаар сар хүртэл сунгаад хавсралтаар 2018 оны 7 дугаар сарын 1 гэхэд дуусгахаар дахин сунгасан байгаа. Одоогийн байдлаар санхүүжилт 300.0 сая төгрөг дутуу аваагүй байгаа. Түүн дээр чанарын баталгааны 5% болох 250.0 сая төгрөг үлдсэн. Гэрээний сунгасан эцсийн хугацаа 2018 оны 7 дугаар сарын 1 байгаа учир бид дутуу ажлыг гүйцэтгүүлж үлдэгдэл санхүүжилтийг олгох эсэхийг шийдвэрлэж ажиллана.

2.4. Гурвалсан гэрээнд тусгасан ажлуудыг гэрээний хугацаанд гүйцэтгэх тухай үүрэг даалгавар өгсний дагуу “Сан”ХХКомпанид албан бичиг хүргүүлснээр Халуун усны барилга, автозамын ажлыг 100% гүйцэтгэж дуусган тайланг ирүүлээд байна. Тайланг хавсаргав. Ахуйн үйлчилгээний барилгын засварын ажил хийгдэж байна. Гурвалсан гэрээг урьдчилсан байдлаар дүгнэсэн. Нэгдсэн тайлангийн эцсийн хугацааг 2018 оны 8 дугаар сарын 15 болтол сунгах саналтай байна. Тус төслийн хүрээнд дутуу хийгдсэн ажлыг тоо хэмжээгээр нь үнэлэхэд 18 250 000 төгрөгийн ажил болж байсан ба гэрээнд заагдсан санхүүжилтээс 300.0 сая төгрөгийг гүйцэтгэгч аваагүй байгаа болохыг харгалзаж үзэх шаардлагатай байх гэж үзэж байна.

Ажлыг бүрэн дууссаны дараа ашиглагч байгууллага, төслийн баг хамтарсан үзлэг шалгалт хийж нэгдсэн дүгнэлтээ гаргах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Төслийн хяналт:

Тус төслийн тухайд хяналтыг аймгийн МХГазар, БХБЯамны БХТөв, “Төслийн менежрийн баг”, аймгийн Орон нутгийн өмчийн газраас шалгаруулсан зөвлөх инженерүүд, аймгийн ГХБХБГазар, орон нутгийн хяналт гэх мэт олон хяналтын байгууллагууд ажиллаж байсан болно. Захиалагчийн хяналтыг 2014-2015 онд орон нутаг гүйцэтгэж байсан ба 2016 оноос одоог хүртэл БХТөв ерөнхий хяналтын үүргийг гүйцэтгэж байсан болно. Бид ерөнхий захиалагчтай хяналтын гэрээ хийж орон нутгийн хяналтын үүргийг гүйцэтгэж байсан ба хяналтын зардлаас зохиогчийн хяналтын зардлын 20%-ийг суутгасан дүнгийн 30%-ийг

авах гэрээ байгуулж ажилладаг болно.Тиймээс гэрээг дүгнэх асуудал дээр бодолцож үзэх шаардлагатай гэсэн саналтай байна

Зураг төсвийн дагуу гүйцэтгүүлээгүй төсөл арга хэмжээ.

Дулааны шугамын өөрчлөлтийг “Тандирс од”ХХКомпани нь трасс өөрчлөхийг зөвшөөрсөн ба гүйцэтгэлийн зураг гаргаж баталгаажуулсан байна. 8 дугаар сарын 15-ний дотор тайланд хавсаргаж хүргүүлнэ

Тайлан мэдээ

2.15. Тус төслийн тайланг БХБЯаманд хагас жил, жилийн эцсийн тайланд тусгаж хүргүүлж байсан. Мөн төслийн ерөнхийлөн захирагч БХБЯамны сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээ, аймгийн ГХБХБГазрын дарга БХТөвийн захиралтай байгуулсан үр дүнгийн гэрээнд тус төслийн гүйцэтгэл тайланг тусгасан байсан ба тайланг тухай бүрт хүргүүлж жил бүр дүгнүүлж ажиллаж байсан байдлыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзэж байна.

Бусад тайлбар:

1.Гэрээний дагуу ажлыг гүйцэтгэж байсан боловч хөрөнгө оруулалтын асуудал шийдвэрлэгдээгүйгээс шалтгаалан зарим ажлууд удаашралтай явагдаж байсан. 2014 онд дулааны шугамын ажлыг гүйцэтгэж ашиглагчид хүлээлгэж өгч ажиллуулсан. Тухайн жилд дулааны алдагдал огт байхгүй ашиглагчийг 100% дулаанаар хангаж байсан боловч 2015 ,2016 онд дулааны алдагдал ихтэй зуух бүрэн хүчин чадлаараа ажиллахгүй байсан нь хатуулаг өндөртэй уснаас шалтгаалсан гэж мэргэжлийн баг үзэж зөвлөмж өгснөөр 2 зуухыг бүрэн сольж ОХУ-д үйлдвэрлэсэн 72000000 төгрөгийн өртөгтэй тогоогоор сольж цэвэр усны тэжээлийн шугаманд ус зөөлрүүлэх төхөөрөмж тавьж гүйцэтгэгч өөрийн зардлаар лаборант бэлтгэж ашиглалтын горимыг жигдрүүлж ажилласан.

2.Тус дулаалгын материал Корунтыг “Сан”ХХКомпани анх удаа Монгол улсад нэвтрүүлж оруулсан ба зохиогч тус материалыг ашиглахыг зөвшөөрсөн. Тус материал нь тохирлын гэрчилгээтэй ашиглаж болно гэсэн Монгол улсын стандарт хэмжил зүйн газраас гаргасан дүгнэлттэй материал юм.Дулааны алдагдлыг төв шугамд байхгүй гэж үзэж байгаа . Хэрэв дулааны алдагдал байсан бол Цэцэрлэг сум нь цэвдэгийн эрчимтэй бусад хамаарагддаг тул газар нь хонхойж цөмрөх шинж тэмдэг илрэх ёстой .Тус шугам нь 4 жилийн турш ашиглагдаж байгаа боловч хөрсний тийм шинж тэмдэг илрээгүй болно. Харин худгуудын тухайд дулааны алдагдал байгаа гэж төслийн баг болон улсын комисс үзэж байгаа. Тэр зөрчил дулагдлыг 2018 оны 8 дугаар сарын 15-ны дотор арилгуулж ажиллана.

3.Уурын зуухны гадна тал, яндангийн тухайд засварлах боломжгүй гэж гүйцэтгэгч компани үздэг.Учир нь тогоо солих , худаг гаргахад 140,0 сая төгрөг илүү зарцуулсан гэж тайлбарладаг боловч барилгын гадна фасадны өнгө будгийг сэргээх үүрэг даалгавар өгсөн байгаа.

4.Цэвэр усны шугамын хоолойг Пенополиуртанаар бүрэн дулаалсан байгаа. Хэрэв дулаалга муутай байсан бол Цэцэрлэг сум нь хүйтний эрчмээрээ Монгол улсад 2 дугаарт ордог сум тул шууд хөлдөх байсан.

5.Цэвэрлэх байгууламж , халуун ус зэрэг засвар үйлчилгээ шаардагдах ажлуудыг 2018 оны 8 дугаар сарын 15 гэхэд засварлуулж ашиглагчид хүлээлгэж өгнө.

6.2017 оны 12 дугаар сард ажилласан комисс дулааны алдагдлыг хэмжиж үзэхэд өгөх буцахын температурын зөрүү 15 хэм байсан нь дулаан алдагдалгүй хэвийн гэж дүгнэж байсан. Ашиглалтын мөчөд гарсан гүйцэтгэгчээс шалтгаалсан зөрчил дутагдлуудыг барилгын туршилт тохируулгын хугацаанд арилгуулж ажиллана. Мөн дулааны алдагдал нь дулааныг авч ашиглаж байгаа барилга байгууламжийн дулаан алдагдлаас шалтгаалдаг гэдгийг бодолцож үзэх шаардлагатай. Тухайлбал хамгийн том хэрэглэгч болох сургуулийн төв байр гэхэд л хана нь цуурсан цонх хаалгаар дулаан алддаг гэх мэт шалтгаанаар МХГазрын улсын байцаагчийн дүгнэлт гарсны улмаас шинэ сургууль төлвөлсөн. Тус сумын барилга байгууламжийн тухайд ихэвчлэн 1980 оноос өмнө аж ахуйн аргаар баригдсан модон хийцтэй барилгууд байдаг нь нэсжилтын хувьд өндөр, ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжууд байдаг гэдгийг бодолцож үзэх шаардлагатай.

7.Улсын комиссын өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2018 оны 8 дугаар сарын 15 гэхэд шалгаж бүрэн дуусгаж ашиглагчид хүлээлгэж өгч ажиллана.

Тайлан гаргасан:

ГХБХБГазрын БХБХэлтсийн дарга  Б.Энхжаргал

Аймгийн ОНӨГ-аас ирүүлсэн санал


**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ГАЗАР**


67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Уранцэцэг буя
АЗДТГ-ий байр 2 өсгөсү 1 давхар
Утас: 7033 8848, 70338821, Факс: 70360848
Э-мэйл: khuvsqul.tander@khs.gov.mn
Вэбсайт: http://umch.khs.gov.mn

2018.06.29 № 1/642
Тайлбар -ийг № -т

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР О.ГАНБОЛД ТАНАА

Цэцэрлэг сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилтэд Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын газраас өгсөн аудитын дүгнэлтийн төсөлд өгөх тайлбар тодруулгыг, нотлох баримтын хамт хавсралтаар хүргүүлэв.

ДАРГА  Б.БОЛД



03/43

Гүйцэтгэлийн аудитаар илэрсэн зөрчлийг тухай бүр танилцуулан, санал солилцож, нотлох баримтад тулгуурлан ажилласан бөгөөд тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Орон нутгийн өмчийн газрын 2018 оны
6 дугаар сарын 27-ны өдрийн 1/842
дугаар албан бичгийн хавсаргалт

**СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС ӨГЧ БУЙ
ДҮГНЭЛТИЙН ТӨСӨЛД ХҮРГҮҮЛЭХ ТАЙЛБАР ТОДРУУЛГА**

Аудитын дүгнэлтийн 1.8 дахь хэсэгт “Цэцэрлэг сумын төвийн шинэчлэл төслийн тендерийн баримт бичгийн иж бүрдэлт хангалтгүй” гэсэн байна.

Тус газар нь тендер шалгаруулалтын баримт бичгийн бүрэн хавтаст хэрэг болгон аймгийн Архивын тасагт хүлээлгэн өгсөн бөгөөд уг төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баримт бичгийг захиалагч (аймгийн Засаг даргын Тамгын газар)-аас ирүүлээгүй тул худалдан авах ажиллагааны баримт бичгийн хавтаст хэрэгт төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баримт бичиг дутуу архивлагдсан болно.

Аудитын дүгнэлтийн 2.22 дахь хэсэгт “Цэвэрлэх байгууламжийн ажил, Ахуйн үйлчилгээний барилгаас бусад барилга байгууламжийг 2016 онд хүлээн авч акт үйлдсэн хэдий ч өнөөг хүртэл орон нутгийн өмчид бүртгээгүй байна” гэжээ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 86 дугаар тогтоолоор баталсан журмын 4.2 дахь хэсэгт “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь улсын төсвийн хөрөнгө оруулалт, банкны зээл, хандив, тусламж, бэлэглэл, өр төлбөрт тооцон үл хөдлөх хөрөнгө олж авбал тухай бүр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт мэдэгдэж, уг хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу бүртгэлд тусгах зөвшөөрөл авна” гэж заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд бэлтгэсэн өмч хөрөнгийг орон нутгийн өмчид шилжүүлэн авах талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт аймгийн Засаг даргын 2017 оны 1/1121, Барилга хот байгуулалтын сайдад аймгийн Засаг даргын 2018 оны 1/40 дүгээр албан бичгүүдийг тус тус хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна. Дээрх тогтоол шийдвэрт зааснаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийг орон нутгийн өмчийн данс бүртгэлд бүртгэх бололцоогүй байгааг дүгнэлт гаргахад харгалзан үзнэ үү!

Аймгийн Засаг даргын 2017 оны 1/1121, 2018 оны 1/40 дүгээр албан бичгүүдийн хуулбарыг хавсаргав.

Аймгийн ИТХ-аас ирүүлсэн санал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТИЙН ГАЗРЫН ДАРГА
О.ГАНБОЛД ТАНАА

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨДӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН АЖЛЫН АЛБА

17102, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урсурса баг
16-дугаар хороо, 1 д/дугаар, Утас: 7038 3330
Э-мэйл: audit@hgov.mn
Бүсэд: hgov.mn

2018.06.29 № 1/129
Төсөл: 2017.06.21 № 05/524

Тайлангийн төсөлд санал
хүргүүлэх тухай

Танай ирүүлсэн сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Аудитын зөвлөмжөөр үүрэг өгч байгаа байгууллага албан тушаалтнуудын зөвлөмжийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг 2018 оны 10 дугаар сард багтааж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх
2. Тус суманд хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын чанар үр дүнд аймгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, Хот байгуулалт, дэд бүтцийн хороо, Төсөв санхүү, эдийн засгийн хороог бүрэлдэхүүнээр нь орон нутагт нь ажиллуулж хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж үнэлэлт дүгнэлт өгөх
3. Зураг төслийн дагуу хийгдээгүй ажлуудыг гүйцэтгэгч компаниар дахин гүйцэтгүүлэх
4. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тогтоолын төсөл боловсруулж батлуулах

ДАРГА

Ц.ГОНЧИГ

Тайлангийн төсөлтэй санал нэг байна гэж үзээд тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

Аймгийн ЗДТГ-аас ирүүлсэн санал



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАР**

67123, Мөрөн, Хөвсгөл аймаг
Утас: 70382216
www.khovsgol.gov.mn

2018.06.29 № 6/1445
таний _____-ны № _____-т

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

"Сумын төвийн шинэчлэл" /ХӨА-2018/01/-ГА/
гүйцэтгэлийн аудитын төсөлтэй танилцаж
холбогдох саналыг хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН
БОДЛОГ ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА **Э.АЗЗАЯ**



132810

“Сумын төвийн шинэчлэл” төслийн хэрэгжилт, үр дүн, үр ашиг
гүйцэтгэлийн аудит хийсэн зөвлөмжийн хэрэгжилт

Д/д	Зөвлөмж	Тайлбар
1	Ашиглалтанд орсон барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах ажлыг зохион байгуулах.	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас төслийн хүрээнд 12 барилга, байгууламж ашиглалтанд орж байгаатай холбоотой паспортжуулах ажлыг 5 дугаар сард хийж дуусгасан.
2	Барилга байгууламжийн нэгдсэн бүртгэл хөтлөх, хадгалах, мэдээллийн сан буй болгох, хяналт тавих.	Барилга байгууламжийн гүйцэтгэлийн бичиг баримтыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар хүлээн авч аймгийн Засаг даргын Тамгын газрын архивт хүргүүлэн ажиллана. Нийт 12 барилга байгууламжийн ажлын Цэвэрлэх байгууламж, Ахуй үйлчилгээний ажлын гүйцэтгэлийн материал хүлээгдэж байна.
3	Улсын комисст ажилласан албан хаагчдад ажлын хариуцлага тооцож, дутуу ажлуудыг гүйцэтгүүлэх.	Аймгийн засаг даргын 2016.07.22-ны А/384 тоот захирамжаар Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын хэлтсийн дарга Б.Энхжаргалаар ахлуулсан төслийн менежерийн баг гурвалсан гэрээний дагуу ажилласан. Мөн 2017.07.28-ны А/516 тоот аймгийн Засаг даргын захирамжаар улсын комисс хүлээн авч дутуу ажлуудыг гүйцэтгүүлэх үүрэг даалгавар өгсөн бөгөөд биелэлт 85%-тай ажиллаж байна. Гэрээг 2018.07.01-нд дүгнэхээр хүлээгдэж байна.

Цэцэрлэг суманд “Сумын төвийн шинэчлэл” төслийг гүйцэтгэгч компаниуд болох “Сан” ХХК, “Туурайн тамга” ХХК-уудтай аймгийн Засаг даргын Тамгын газар гэрээ байгуулан ажилласан бөгөөд холбогдох компаниудтай хамтран ажиллах гэрээ байгуулаагүй болно. Иймд үндсэн гүйцэтгэгч компанитай хамтарч ажиллах боломжтой.

Тайлангийн төсөлтэй санал нэг байна гэж үзээд тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэв.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 даяар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2018.06.08 № ХӨА/2018/011/ГА-01

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТӨСЛИЙН МЕНЕЖЕР Н.БЯМБАДОРЖ,
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА, УЛСЫН
КОМИССЫН ДАРГА Б.ЭНХЖАРГАЛ
НАРТ

Зөрчил арилгуулах тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалга, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн “Сумын төвийн шинэчлэл” төслийн хэрэгжилт, үр дүн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд: “Сумын төвийн шинэчлэл” төслийн хүрээнд “САН” ХХК нь зарим нэгэн ажлыг дутуу хийсэн тул Захиалагчийн зүгээс ажлыг гүйцээж хийлгэхээр гурван талт гэрээ байгуулж тодорхой хугацаатай үүрэг даалгаврын хүснэгт бэлтгэн хавсалтаар баталгаажуулсан байна. (Гэрээний дугаар №01) Аудитын хугацаанд дээрх үүрэг даалгаврын хэрэгжилтэнд үзлэг шалгалт хийхэд дутуу ажлыг гүйцээж хийлгээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-г (...аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...) Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.5-д (...Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журмын шаардлага хангаагүй алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө...) гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Дугаар №01 тоот “Гэрээ”-нд заасан ажлуудыг 2018 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн дотор гүйцээж хийлгэн, гүйцэтгэлийг нотлох баримтын хамт Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Н.Бямбадорж, уг газрын барилга хот байгуулалтын хэлтсийн дарга Б.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЭГСЭН:
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын
Ахлах аудитор *[Signature]*
Аудитор *[Signature]*
6717144193
РЦА0062 907005

ЗӨВШӨӨРСӨН:
Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын дарга
Н.Бямбадорж
Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын барилга хот
байгуулалтын хэлтсийн дарга
Б.Энхжаргал

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдавгүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас төвөгсөн албан шаардлага, төлбөрийн өнтгэ цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд “ирүүлнэ” гэж заасны дагуу харууцааг албан тушаалтанд харууллага мөсцүүлгээр эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

67123, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Урандөш баг
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас, факс: 70-38 37-93
Э-мэйл: khvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ГАЗРЫН
ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА
Н.БЯМБАДОРЖ ТАНАА

2018.06.14 № ХӨА-2018/01/ГА-01/27

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2, 19 дүгээр зүйлийн 19.1, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын захиалга, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалын дагуу "Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр дүн, үр ашиг"-т гүйцэтгэлийн аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Засаг дарга Л.Ганболдын "Сан" ХХК-ийн ерөнхий захирал Д.Чимид-Осортой 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан "ХӨ-2014/84-А-07С дахин" дугаартай "Сумын төвийн шинэчлэл" төслийн хүрээнд "Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын төвд ахуйн үйлчилгээ-халуун усны төв, цэвэрлэх байгууламж, авто замын зураг төсөл боловсруулах, угсралт тохируулгын ажил гүйцэтгэх гэрээний сунгалт" гэрээний сунгалтаар хийгдэх ажил болох "Авто замын угсралтын ажил 407962079 (Дөрвөн зуун долоон сая есөн зуун жаран хоёр мянга далан есөн төгрөг) төгрөг, ахуйн үйлчилгээний барилга 136878464 (Нэг зуун гучин зургаан сая найман зуун далан найман мянга дөрвөн зуун жаран дөрвөн төгрөг) төгрөг, цэвэрлэх байгууламжийн ажил 153400000 (Нэг зуун тавин гурван сая дөрвөн зуун мянга) төгрөг, нийт 698240543 (Зургаан зуун ерөн найман сая хоёр зуун дөчин мянга таван зуун дөчин гурван төгрөг) төгрөгийн төсөл, арга хэмжээг гэрээнд заасан хугацаанд хэрэгжилтийг хангуулж, ашиглалтад хүлээн аваагүй зөрчил илэрлээ.

Дээрх зөрчил нь Аймгийн Засаг дарга Л.Ганболдын "Сан" ХХК-ийн ерөнхий захирал Д.Чимид-Осортой 2016 оны 07 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан "ХӨ-2014/84-А-07С дахин" дугаартай гэрээний 2-т "Гүйцэтгэгч нь ... ажлыг 2016 оны 07 дугаар сарын 28-ны өдөр эхэлж, 2016 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр ашиглалтад оруулахаар тохиролцов" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т (... аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх ...) Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д (... дараах алдаа зөрчилд төрийн аудитын байгууллага албан шаардлага өгнө ...) гэсэн заалтуудыг үндэслэн ШААРДАХ НЬ:

Дээр дурдсан нийт 698240543 (Зургаан зуун ерөн найман сая хоёр зуун дөчин мянга таван зуун дөчин гурван төгрөг) төгрөгийн зөрчлийг арилгаж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах ажлыг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор зохион байгуулж, хүлээн авч, биелэлтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг

дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Н.Бямбадорж, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилгын хэлтсийн дарга Б.Энхжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ЭГСӨН:
Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор *Ж.Отгончимэг*
Аудитор *Б.Сандуйжав*
6717144193
РЮА0062 9070605

ЗӨВШӨӨРСӨН:
Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга *Н.Бямбадорж*
Хөвсгөл аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын барилгын хэлтсийн дарга *Б.Энхжаргал*

¹ Ахт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас төвлөсөн албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил зэрэгсэн албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

“Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр дүн, үр ашиг”
гүйцэтгэлийн аудитын хураангуй
тайлан

Огноо: 2018.06.29

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ГАГ-ХӨА-2018-01-ГА	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр: Д:	Хөвсгөл аймгийн ТЕЗ, ЗДТГ, ОНӨГ, МХГ, ГХБХБГ, Цэцэрлэг сумын ТЕЗ, /хэрэгжсэн ТАХ/
Аудитын нэр:	“Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр дүн, үр ашиг”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр: ГАБ	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Тэргүүлэх аудитор О.Ганболд, Аудитын менежер Г.Эрдэнэчимэг, Ахлах аудитор Ж.Отгончимэг, Аудитор Б.Сандуйжав

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамарсан хүрээ:

Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр дүн, үр ашигт гүйцэтгэлийн аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан уу?
- Төслийн хэрэгжилт үр дүн, үр ашигтай байна уу?

2.2 Аудитын дүн:

2.2.1 Гол асуулт / аудитын дэд зорилт 1:

Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулсан уу?

Хариулт 1:

ХӨА-2018/01-ГА

Худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжийн дагуу үр дүнтэй, үр нөлөөтэй зохион байгуулсан байна.

2.2.2 Гол асуулт / аудитын дэд зорилт 2:

Төслийн хэрэгжилт үр дүн, үр ашигтай байна уу?

Хариулт 2:

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт бодитой бус, үр нөлөө багатай байна.

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт үр нөлөө, үр дүн муутай байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт үр дүн муутай, зарим арга хэмжээ ашиглалтын шаардлага хангахгүй байна.

Аудитын гол дүгнэлт

“Сумын төвийн шинэчлэл төсөл”-ийн хэрэгжилтэд тавих хяналт муу, төслийн эцсийн үр дүн харагдахгүй байна.

2.3 Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр		Алдаа, зөрчлийн		Үүнээс			
			Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
А	1		2	3	4	5	6	7
1	ТЕЗ	Улсын комисс хүлээж авсан зарим ажлуудын гэрээг дахин сунгасан байна.	1	18,2	1		1	
2	Авто замын ажил	Сумын төвд баригдсан авто замын дагуу шуудуу татахаар зурагт тусгасан ч энэхүү ажлын оронд уулын үерийг зайлуулах шуудуу татсан байна. Өөрчлөлт хийсэн зохиогчийн зөвшөөрөл байхгүй байна.	1	407,9	1		1	
3	Ахуйн үйлчилгээний барилга	Ханын битүүмжлэл муу шал хананы завсраар шороо, цас орж байна.	1	136,9	1			

4	Цэвэрлэх байгууламж	Ханын битүүмжлэл муу хийгдсэнээс шал, ханын завсраар шороо, цас орж байна. Үүний улмаас дулаан алдагдал ихтэй, халаах хэрэгсэл барилгыг халааж чадахгүй байна. Лагийн болон цэвэрлэгдсэн усны шугам хоолой дулаалга хангалтгүйгээс өвлийн улиралд хөлдсөн байна. Лагийн талбай болон ус зайлуулах хоолой өвлийн улиралд цасанд дарагдаж ашиглалтын байдалд саад учруулж байна.	1	153,4	1			
5	Халуун усны барилга	Чийг ихтэй байгаагаас дотор засал ховхорч мөөгөнцөр үүсэх шинж тэмдэг илэрсэн байна. Агааржуулалт муу ажиллаж, цанталт үүсэн агааржуулалтаас ус гоожсон байна. Халуун усны гадна цэвэр усны шугам дулаалгагүй учраас хөлдөлт үүссэн байна.	1	86,5	1			
6	Усан сангийн барилга	Ус нөөцлөх савыг хавтангууд залгаж хийсэн бөгөөд савны нийт эзлэхүүний хэмжээгээр ус нөөцлөх үед хавтангуудын залгаасаар ус алддаг болсон байна.	1	120,0	1			
7	ТЭЗ	2016 оны 10 дугаар сарын 23-ний өдөр 16 хүний бүрэлдэхүүнтэй “Улсын комисс” хүлээж авсан боловч холбогдох баримт бичгүүдийг архив болон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байна.	1		1			
8	ОНӨГазар	Зөвлөх үйлчилгээний дүгнэлтэд: “Корунд” тусгаарлагчаас шилэн хөвөн дулаан тусгаарлагч сайн тусгаарлаж байгааг тодорхойлов” гээд, дулааны алдагдлыг багасгах зорилгоор “Корунд” дулаалгыг	1	15,0	1			

		сайжруулах эсвэл давхарлаж шилэн хөвөн буюу хөөсөнцөр дулаалга хийх зэрэг 7 зүйлийн зөвлөмж өгсөн байна. Эдгээр зөвлөмжөөс ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах гэсэн зөвлөмжөөс бусад нь хэрэгжээгүй байна. Зөвлөх үйлчилгээ 15,0 сая төгрөгөөр хийлгээд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үр дүнгүй зарцуулсан байна гэж гүйцэтгэлийн аудитаар үзэж байна.					
9	ГХБХБГазар	Захиалагчийн хяналтын зардлыг “Захиалагчийн хяналтын зардал” дансаар дамжуулахгүй шууд зарцуулсан байна. Мөн уг зардлын зарим нэгэн хэсгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	20,9	1		
10	Тэсийн –Илч ХХК	Ахуйн үйлчилгээний барилгыг ашиглалтад хүлээн аваагүй бөгөөд халаалтаар хангаж байна. Энэ нь: Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 -дахь хэсгийг зөрчсөн бөгөөд “Тэсийн илч” ОНӨХХК жилд халаалтын төлбөр болох 4.5 сая төгрөгийн алдагдалд орж байна.	1	4,5	1		
11	Тэсийн –Илч ХХК	Халуун усны барилгын ус халаах систем нь бүрэн хүчин чадлаар ажиллах үед усаа халааж чаддаггүй, цахилгааны зарцуулалт ихтэй зэргээс түрээслэн ажиллуулж байгаа иргэд нь халаалтын төлбөр өгөх боломжгүй байна. Үүний улмаас түрээслүүлэгч жилд 1.1 сая төгрөгийн халаалтын төлбөрийн орлого олох боломжоо алдаж байна.	1	1,1	1		

12	ОНӨГазар	Дууссан ТАХ-г Нягтлан бодох бүртгэлд бүртгэж ажиллаагүй байна. Тухайлбал: Цэвэрлэх байгууламжийн ажил, Ахуйн үйлчилгээний барилгын ажлаас бусад барилга, инженерийн хийцтэй шугам сүлжээг УК 2016 онд хүлээн авч акт үйлдсэн хэдий ч өнөөг хүртэл орон нутгийн өмчид бүртгэн, Нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.	1	5000,0	1		
		ДҮН	12	5964,4	12		2

Гурав. Баталгаажуулалт

Ахлах аудитор

Аудитор

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор

/Ж.Отгончимэг./

/Б.Сандуйжав.

/Г.Эрдэнэчимэг.

/О.Ганболд/

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018.06.29	Аудитын нэр:	“Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр дүн, үр ашиг”	Аудитын код:	ХӨА-2018/01/-ГА
Шалгагдсан байгууллагын нэр:		Хөвсгөл аймгийн ТЕЗ, ЗДТГ, ОНӨГ, МХГ, ГХБХБГ, Цэцэрлэг сумын ТЕЗ, /хэрэгжсэн ТАХ/			Сая төгрөгөөр

№	Аудитын зорилт чиглэл	Тоо	Аудитын зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
					Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
1	Сумын төвийн шинэчлэл төслийн хэрэгжилт, үр дүн, үр ашигт	1	Улсын комисс хүлээж авсан зарим ажлуудын гэрээг дахин сунгасан байна.	18,2	Албан шаардлага	2018.06.08	01/26	ГХБХБГ-н дарга ГХБХБГ-н БХБХ-н дарга	Н.Бямбадорж Б.Энхжаргал
2	гүйцэтгэлийн аудит хийж дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж дүгнэлт, зөвлөмж боловсруулахад аудитын зорилт чиглэгдэнэ.	1	Сумын төвд баригдсан авто замын дагуу шуудуу татахаар зурагт тусгасан ч энэхүү ажлын оронд уулын үерийг зайлуулах шуудуу татсан байна. Өөрчлөлт хийсэн зохиогчийн зөвшөөрөл байхгүй байна.	407,9	Албан шаардлага	2018.06.14	02/27	ГХБХБГ-н дарга	Н.Бямбадорж
3		1	Ханын битүүмжлэл муу хийгдсэнээс шал хананы завсраар шороо, цас орж байна.	136,9					
4		1	Ханын битүүмжлэл муу хийгдсэнээс шал, ханын завсраар шороо, цас орж байна. Үүний улмаас дулаан алдагдал ихтэй, халаах хэрэгсэл барилгыг халааж чадахгүй байна. Лагийн болон цэвэрлэгдсэн усны шугам хоолой дулаалга	153,4					

			хангалтгүйгээс өвлийн улиралд хөлдсөн байна. Лагийн талбай болон ус зайлуулах хоолой өвлийн улиралд цасанд дарагдаж ашиглалтын байдалд саад учруулж байна.						
5		1	Чийг ихтэй байгаагаас дотор засал ховхорч мөөгөнцөр үүсэх шинж тэмдэг илэрсэн байна. Агааржуулалт муу ажиллаж, цанталт үүсэн агааржуулалтаас ус гоожсон байна. Халуун усны гадна цэвэр усны шугам дулаалгагүй учраас хөлдөлт үүссэн байна.	86,5	Зөвлөмж	2018.06.29	A/33	ГХБХБГ-н дарга	Н.Бямбадорж
6		1	Ус нөөцлөх савыг хавтангууд залгаж хийсэн бөгөөд савны нийт эзлэхүүний хэмжээгээр ус нөөцлөх үед хавтангуудын залгаасаар ус алддаг болсон байна.	120,0	Зөвлөмж	2018.06.29	A/33	ГХБХБГ-н дарга	Н.Бямбадорж
7		1	2016 оны 10 дугаар сарын 23-ний өдөр 16 хүний бүрэлдэхүүнтэй “Улсын комисс” хүлээж авсан боловч холбогдох баримт бичгүүдийг архив болон ашиглагч байгууллагад шилжүүлээгүй байна.		Зөвлөмж	2018.06.29	A/33	ГХБХБГ-н дарга	Н.Бямбадорж
8		1	Зөвлөх үйлчилгээний дүгнэлтэд: “Корунд” тусгаарлагчаас шилэн хөвөн дулаан тусгаарлагч сайн тусгаарлаж байгааг тодорхойлов” гээд, дулааны алдагдлыг багасгах зорилгоор “Корунд” дулаалгыг сайжруулах эсвэл давхарлаж шилэн хөвөн буюу хөөсөнцөр дулаалга хийх	15,0	Зөвлөмж	2018.06.29	A/33	ГХБХБГ-н дарга	Н.Бямбадорж

			зэрэг 7 зүйлийн зөвлөмж өгсөн байна. Эдгээр зөвлөмжөөс ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах гэсэн зөвлөмжөөс бусад нь хэрэгжээгүй байна. Зөвлөх үйлчилгээ 15,0 сая төгрөгөөр хийлгээд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үр дүнгүй зарцуулсан байна гэж гүйцэтгэлийн аудитаар үзэж байна.						
9		1	Захиалагчийн хяналтын зардлыг “Захиалагчийн хяналтын зардал” дансаар дамжуулахгүй шууд зарцуулсан байна. Мөн уг зардлын зарим нэгэн хэсгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	20,9	Зөвлөмж	2018.06.29	A/33	ГХБХБГ-н дарга	Н.Бямбадорж
10		1	Ахуйн үйлчилгээний барилгыг ашиглалтад хүлээн аваагүй бөгөөд халаалтаар хангаж байна. Энэ нь: Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 -дахь хэсгийг зөрчсөн бөгөөд “Тэсийн илч” ОНӨХХК жилд халаалтын төлбөр болох 4.5 сая төгрөгийн алдагдалд орж байна.	4,5	Зөвлөмж	2018.06.29	A/33	ГХБХБГ-н дарга	Н.Бямбадорж
11		1	Халуун усны барилгын ус халаах систем нь бүрэн хүчин чадлаар ажиллах үед усаа халааж чаддаггүй, цахилгааны зарцуулалт ихтэй зэргээс түрээслэн ажиллуулж байгаа иргэд нь халаалтын төлбөр өгөх боломжгүй байна. Үүний	1,1	Зөвлөмж	2018.06.29	A/33	ГХБХБГ-н дарга	Н.Бямбадорж

			улмаас түрээслүүлэгч жилд 1.1 сая төгрөгийн халаалтын төлбөрийн орлого олох боломжоо алдаж байна.						
12		1	Дууссан ТАХ-г Нягтлан бодох бүртгэлд бүртгэж ажиллаагүй байна. Тухайлбал: Цэвэрлэх байгууламжийн ажил, Ахуйн үйлчилгээний барилгын ажлаас бусад барилга, инженерийн хийцтэй шугам сүлжээг УК 2016 онд хүлээн авч акт үйлдсэн хэдий ч өнөөг хүртэл орон нутгийн өмчид бүртгэн, Нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.	5000,0	Зөвлөмж	2018.06.29	A/33	ОНӨГ-н дарга	Б.Болд
Нийт дүн				5964,4					

Бэлтгэсэн: Ахлах аудитор
Аудитор

Ж.Отгончимэг
Б.Сандуйжав

ОГНОО:
ОГНОО:

Анхан шатанд хянасан: Аудитын менежер
Хоёр дахь шатанд хянасан: Дарга, тэргүүлэх аудитор

Г.Эрдэнэчимэг
О.Ганболд

ОГНОО:
ОГНОО: